*“Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6 дугаар хавсралт*

## ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ ХҮСНЭГТ

2018.09.25 Улаанбаатар хот

| **Шийдвэр-ийн дэс дугаар** | **Зүйл, заалтын дэс дугаар** | **Шийдвэрийн нэр, огноо, дугаар, агуулга** | **Хэрэгжилтийн явц** | **Үнэлгээ, (хүчингүй болсон, хяналтаас хасуулах тухай санал)** | **Тасарсан болон удааширч байгаа шалтгаан** |
|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| **1.б.Улсын Их Хурлын тогтоол** | | | | | |
| “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай” 2016.11.03-ны өдрийн 51 дугаар тогтоол | 2. | Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө батлан, холбогдон гарах зардлыг жил бүрийн улсын төсөвт тусгаж байхыг Монгол Улсын Засгийн газар /Ж.Эрдэнэбат/-т, хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Авлигатай тэмцэх газар /Х.Энхжаргал/-т тус тус даалгасугай. | НҮГ-ын хэмжээнд 2018 онд хэрэгжүүлэх авилгын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө гарган, уг төлөвлөгөөний хүрээнд 2018 оны 3 дугаар улиралд дараах ажлыг хэрэгжүүлсэн байна. Үүнд:<br>- Авлигын эсрэг хууль тогтоомж, зохион байгуулж буй арга хэмжээг мэдээллийн самбарт байршуулан газрын ажилтан, албан хаагчдад авилгын эсрэг хууль тогтоомжийг сурталчилан ажиллаж байна.<br>- Ажлын байрны сул орон тооны зар, холбогдох утасны дугаар, хаягийн мэдээллийг www.khangardi.mn цахим сайт болон байгууллагын мэдээллийн самбарт тогтмол байршуулан нийтэд мэдээлж байна.<br>- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн нээлттэй хэлбэрээр зохион байгуулж, тайланг сар бүрийн 01-ний өдрийн дотор | 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газарт хүргүүлэн ажиллаа. | | |
| Хэсгийн дундаж: 100 хувь | | | | | |
| 1.в.Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол | | | | | |
| | | | | | |
| 1.г.Ерөнхийлөгчийн зарлиг | | | | | |
| | | | | | |
| 1.д.Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, тэмдэглэл | | | | | |
| **1.е.Засгийн газрын тогтоол** | | | | | |
| 2018 оныг “Хариуц- -лагын жил” болгон зарлах тухай 2018.01.31-ний өдрийн 32 дугаар тогтоол 2018 оныг | 2.1 | Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгасан төсөл, арга хэмжээг хугацаанд нь зохион байгуулан дүгнэж ажиллах | НЗЗ-ны байруудын зоогийн газруудаар үйлчлүүлэх төрийн албан хаагчдын хүнсний хэрэгцээнд эрүүл ахуйн стандарт аюулгүй байдлын шаардлага хангасан чанартай баталгаат бүтээгдэхүүнээр үйлчлэх зорилтын хүрээнд:<br>- Газрын даргын баталсан удирдамжийн дагуу ажлын хэсэг 2018.09.03-2018.09.17-ны өдрүүдэд НЗЗ-ны 1, 2, 5 дугаар байрны зоогийн газар, цайны газруудын орчин, эрүүл ахуйн нөхцөл, зоогийн газрын хэрэгслийн угаалга, цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт, техник тоног төхөөрөмжинд тавигдах шаардлага, түүхий эд хүлээн авах, хадгалах нөхцөл болон ажиллагсдын эрүүл ахуй, ариун цэвэрт хяналт-шинжилгээ хийж, зөрчил дутагдлыг арилгаж ажиллаа.<br>- НЗЗ-ны 2 дугаар байрны хурлын зааланд болсон Нийслэлийн удирдах ажилтны шуурхай зөвлөгөөн 16 удаа, ЗАА-ны албан хаагчдын шуурхай зөвлөгөөн 15 удаа, НЗД-ын Зөвлөлийн хурал 23 удаа, НИТХ-ын чуулган 7 удаа, шагнал гардуулах, гарын үсэг зурах үйл ажиллагаа 10 удаа, бусад чиглэлийн хурал, зөвлөгөөн 480 удаа болж, нийт 600 орчим үйл ажиллагааны хурлын заалны үйлчилгээний бэлтгэл ажлыг ханган ажиллав. | 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| “Хариуц-<br>-лагын жил” болгон зарлах тухай 2018.01.31-ний өдрийн 32 дугаар тогтоол | | | - НЗЗ-ны 5Б байрны Б зааланд 134 удаагийн хурлаар 3484 хүнд, 5В байрны Иргэний танхимд болсон 109 удаагийн хурлаар 14313 хүнд тус тус үйлчиллээ.<br>- Нийслэлийн Хангарди ордны Зоогийн газар 70 гаруй хүндэтгэлийн хүлээн авалтыг зохион байгуулж, 3505 хүнд үйлчилгээ үзүүлэхийн зэрэгцээ 15 удаагийн хурлын цай, завсарлагааг зохион байгуулж, 1500 хүнд үйлчилсэн байна. Түүнчлэн хээрийн зоогийн үйлчилгээг 4 удаа зохион байгуулж 325 хүнд зоогийн үйлчилгээг амжилттай үзүүлсэн байна.<br>Олон нийтийн арга хэмжээ, тэмдэглэлт баяр ёслолын үйл ажиллагааны үйлчилгээнд зохион байгуулалттайгаар оролцох зорилтын хүрээнд:<br>- Үндэсний их баяр наадмын үйл ажиллагааны үеэр Хүй 7 худагт зоогийн үйлчилгээ, Төв цэнгэлдэх хүрээлэнгийн зочдын үйлчилгээ, Нийслэлийн Засаг даргын хүндэтгэл үзүүлэх үйлчилгээний 10, 8, 5 ханатай гэрүүдийг барих, хураах, уяачдын наадмын төв асарт үйлчилгээ үзүүлэх ажлуудыг хариуцан гүйцэтгэж, мөн үеэр 300 гаруй зочид, төлөөлөгчдөд баяр наадмын хүндэтгэлийн зоог, хүлээн авалтын үйлчилгээг үзүүлэн ажиллалаа.<br>- Мөн “Даншиг наадам-Хүрээ цам 2018” шашин соёлын арга хэмжээнд зориулж шаардлагатай бэлтгэл ажлыг хангаж, наадмын үеэр 120 гаруй зочид төлөөлөгчдөд зоогийн үйлчилгээ, төв асрын үйлчилгээ, хүндэтгэлийн үйлчилгээг үзүүлж, нийт 4 удаагийн хүлээн авалтыг амжилттай зохион байгуулсан байна.<br><br>Санхүүгийн үйл ажиллагаатай холбогдон гарах тайлан, мэдээ судалгааг үнэн зөв шуурхай гаргаж, аудитын байгууллагаар үйл ажиллагаагаа дүгнүүлж ажиллах зорилтын хүрээнд:<br>- 2018 оны 1, 2 дугаар улирал, хагас жилийн тайлан, | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 2018 оныг “Хариуц--лагын жил” болгон зарлах тухай 2018.01.31-ний өдрийн 32 дугаар тогтоол | | | төсвийн гүйцэтгэлийн мэдээг гаргаж, хугацаанд нь НЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэс, Нийслэлийн татварын газарт хүргүүлсэн. Мөн мэдээ тайланг шилэн дансанд тухай бүр байршуулан ажиллаж байна.<br>- 2017 оны жилийн эцэс, 2018 оны эхний хагас жилийн үндсэн хөрөнгө, аж ахуйн эд хөрөнгийн тооллогыг хийж, дүн мэдээг газрын даргад танилцуулан, актлагдах хөрөнгийн жагсаалтыг гарган албан бичгээр НӨХГ-т хүргүүлээд байна.<br>Нийслэлийн засаг захиргааны байруудад эрчим хүчний хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлж, эрчим хүчний хэмнэлттэй бүтээгдэхүүн нэмэгдүүлэх зорилтын хүрээнд:<br>- НЗЗ-ны байруудын инженерийн шугам сүлжээний хэвийн ажиллагааг хангах, эвдрэл гэмтлээс урьдчилан сэргийлэх үзлэгийг инженерүүд 7 хоног тутам, албаны дарга сард нэг удаа тус тус тогтмол хийж байна.<br>- Мөн сантехникийн материал, угаалтуурын сифон хоолой, уян хоолойн писсуарийн сифон, халаагуур, почекины ком, писсаур мэдрэгч, батарей зэрэг зайлшгүй шаардлагатай зүйлсийг акт үйлдэн сольж, Хангарди ордны нөөц тэжээл болох дизель генераторыг автомат горимд шилжүүлэн АВР сэлгэн залгагчийг бүрэн засварлаж, туршилтын тохируулгыг хийлээ.<br>- “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн Зүүн түгээх төвтэй хамтран ажиллах гэрээний дагуу тоолуур, гүйдлийн трансформатор баталгаажуулах, хуваарилах байгууламжийг шинэчиллээ. | | |
| | 2.2 | яам, Засгийн газрын агентлаг, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар, төсөвт байгууллага бүр хууль | - Удирдлагын зүгээс байгууллагад ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд байнга хяналт тавин, аливаа зөрчил, дутагдал гаргахаас сэргийлэн ажиллаж байна.<br>- Өргөдөл гомдол хариуцсан албан тушаалтны зүгээс | 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | тогтоомжоор хүлээсэн чиг үүргээ хэлбэрэлтгүй биелүүлж аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн санал хүсэлт, өргөдөл гомдлыг хугацаанд нь шийдвэрлэн хариуг нэг цэгээс шуурхай өгч, төрийн үйлчилгээг хүнд суртал, чирэгдэлгүй зохион байгуулж, ахиц дэвшил гаргах арга хэмжээ авах | байгууллагад ирсэн нийт 181 өргөдөл, гомдлыг тухай бүр www.smartcity.mn цахим системд бүртгэж, удирдлагад танилцуулан, шаардлагатай мэдээллээр хангаж, тайлант хугацаанд ирсэн 180 өргөдлийг шийдвэрлэн хариуг хүргүүлснээр шийдвэрлэлтийн явц 98,41 хувьтай хэрэгжиж байна.<br>- Байгууллагад ирсэн өргөдөл гомдлын явцын тэмдэглэлийг 7 хоног бүр хөтлөн, хугацаанд нь, шуурхай шийдвэрлэж, төрийн үйлчилгээг хүнд суртал, чирэгдэлгүй зохион байгуулахад анхааран ажиллаж байна. | | |
| | 2.3 | төрийн захиргааны бүх шатны байгууллага ажиллагсадтайгаа байгуулсан үр дүнгийн болон хөдөлмөрийн гэрээг хагас, бүтэн жилээр дүгнэж, гэрээний үүргээ хангалтгүй биелүүлсэн удирдлага, албан тушаалтанд холбогдох хуульд заасны дагуу хариуцлага тооцон ажиллаж байх | - НҮГ-ын хэмжээнд нийт 1 ажилтан үр дүнгийн гэрээ, бусад ажилтан, албан хаагч хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр ажил үүргээ гүйцэтгэж байгаа билээ.<br>- НҮГ-ын Захиргаа, санхүүгийн хэлтсийн албан хаагчидтай байгуулсан хөдөлмөрийн гэрээний хагас жилийн биелэлт, үйлчилгээ техникийн ажиллагсдын хөдөлмөрийн гэрээний 3 дугаар улирлын биелэлтийг дүгнэж, ур чадварыг үнэлэх ажлыг 2018.09.25 - 2018.09.30-ны өдрүүдэд зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.<br>- Хөдөлмөрийн гэрээний биелэлт, ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийг дүгнэж, ур чадварын үнэлгээг гаргаснаар гэрээгээр хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлсэн, ажил үүрэгтээ хариуцлагагүй хандсан ажилтан, албан хаагчдад холбогдох хууль, журмын дагуу хариуцлага тооцно. | 100% | |
| | 2.4 | 2018 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог байгуулан төсөл, арга хэмжээг төсвийн жилд багтаан | - Газрын даргын 2018.04.10-ны өдрийн А/23, 2018.08.01-ний өдрийн А/43, 2018.09.06-ны өдрийн А/50 дугаар тушаалуудаар НҮГ-ын 2018 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог томилсон.<br>- НҮГ нь 2018 оны 3 дугаар улиралд нийт 3 ажил, 1 бараа | 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | хэрэгжүүлж ажиллах | худалдан авах ажлыг харьцуулалтын аргаар, бусад ажлыг шууд худалдан авалтын аргаар гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, худалдан авах ажиллагаа явуулсан байна. | | |
| | 2.5 | “Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” Засгийн газрын 2017 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийг хангаж ажиллах. | - ЗГ-ын 2017 оны 01 дүгээр албан даалгаврыг нийслэлийн хэмжээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөөний биелэлтийг сарын бүрийн 05-ны өдрийн дотор, албан даалгаврын биелэлтийг мэдээг улирал бүр гаргаж НЗДТГ-ын ХШҮХ-т хүргүүлэн ажиллаж байна. | 100% | |
| | | Харьяа байгууллага болон салбар, нэгжид сахилга, дэг журмыг сахиулах тодорхой арга хэмжээ авч, төрийн албаны тухай хууль тогтоомж, холбогдох дүрэм, журмыг зөрчсөн төрийн албан хаагчид хариуцлага тооцож тухай бүр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт тайлагнаж байх | - Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах талаар шат дараалсан арга хэмжээ авахаар төлөвлөн ажиллаж буй бөгөөд сахилга хариуцлага, цаг ашиглалтад хяналт шинжилгээ хийх ажлын хэсэг томилогдон ажиллаж байна.<br>- Мөн ажилтан, албан хаагчдын ажлын цагийн бүртгэлийг хурууны хээ мэдрэгч төхөөрөмжөөр бүртгэн, 2018.09.01-ний өдрөөс ажлаас хоцорсон болон эрт тарсан ажилтан, албан хаагчдад ногдуулах хариуцлагыг түүнд олгох ур чадварын нэмэгдэлтэй уялдуулан хасч тооцохоор төлөвлөн ажиллаж байна. | 100% | |
| | 1.2 | Иргэдийг ялгаварлан гадуурхахгүй ижил тэгш, зөв шударга харьцаж, төрийн байгууллагад иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд тавих хяналтыг сайжруулж, хугацаа хэтэрсэн өргөдөл, гомдлыг 2018 оны 09 дүгээр сарын 01-ний өдөрт багтаан шийдвэрлэж, хариуг | - Тайлант хугацаанд ажилтан, албан хаагчид болон иргэдээс ирсэн өргөдөл, гомдлыг тухай бүр хүлээн авч, www.smartcity.mn цахим системд бүртгэн, удирдлагад танилцуулж, 10 хоног тутам явцын тэмдэглэл хөтөлж, шийдвэрлэгдсэн өргөдөл гомдлын хариуг сайтад байршуулан ажиллаж байна.<br>- 2018 оны 3 дугаар улиралд нийт 64 өргөдөл, хүсэлт ирснээс 63 өргөдөл хүсэлтийг хугацаанд нь шийдвэрлэсэн ба шийдвэрлэгдэх шатанд буюу хугацаа дуусах болоогүй 1 өргөдөл байна. Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн өргөдөл гомдол байхгүй бөгөөд мөн хугацаанд гаргасан зөрчилгүй | 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | өгөх, цаашид өргөдөл гомдлыг хугацаанд нь бодитой шийдвэрлэж хэвшүүлэх | болно. | | |
| | 1.3 | Төрийн албан хаагчдын ажлын байрны шинжилгээ хийж, шинжилгээний дүнд тулгуурлан байгууллагын чиг үүргийн давхардал, хийдлийг арилгаж, ажлын бүтээмж, үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах | - Ажилтан, албан хаагчдын гүйцэтгэх чиг үүргийн давхардал, хийдлийг арилгахад тогтмол анхааран ажиллаж буй бөгөөд дотоод хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан ажилтны зүгээс ажилтан, албан хаагч нэг бүрийн ажлын бүтээмжийг шалгаж, үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулахад удирдлагын зүгээс хяналт тавин ажиллаж байна. | 100% | |
| | 1.4 | Төрийн жинхэнэ албан тушаалд сул орон тоо гарсан тохиолдолд тухайн байгууллага болон төрийн холбогдох байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдаас үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингээр шалгаруулж нөхөн томилох замаар төрийн мэргэшсэн албыг бэхжүүлэх | - Тус газрын даргаас бусад ажилтан, албан хаагчид нь Төрийн албаны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т заасан үйлчилгээний албаны ангилалд хамаарах тул уг заалтыг хяналтаас хасуулах саналтай байна. | 100% | |
| | 1.7 | Төрийн албан хаагч албан томилолтын явцад, ажлын болон ажлын бус цагаар ажлын байранд согтууруулах ундаа хэрэглэх явдлыг таслан зогсоох, төрийн байгууллагын байр, ажлын байранд согтууруулах ундаа, мансууруулах бодис, галт | - Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 7 дугаар зүйлд ажлын байранд согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэсэн, хэрэглэсэн үедээ ирсэн болон ажил үүрэг гүйцэтгэсэн, мөн галт болон хүйтэн зэвсэг, тэсэрч дэлбэрэх болон шатамхай бодис, хэрэгслийг ажлын байранд нэвтрүүлэх, хадгалах, хэрэглэх, ашиглахыг хатуу хориглож, ийм үйлдэл гаргасан ажилтантай байгуулсан хөдөлмөрийн гэрээг Ажил олгогчийн санаачилгаар шууд цуцлахаар тусгасан болно. | 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | болон хүйтэн зэвсэг, тэсэрч дэлбэрэх болон шатамхай бодис, хэрэгслийг нэвтрүүлэх, хадгалах, хэрэглэх, ашиглахыг байгууллагын дотоод журамд тусган хориглож, зөрчсөн тохиолдолд хариуцлага тооцох | | | |
| | 1.9 | Төрийн байгууллагад ажлын цаг ашиглалтыг хурууны хээний болон камерын хяналтын системээр байнга бүртгэж, түүнд тавих хяналтыг сайжруулах | - Ажилтан, албан хаагчдын ажлын цагийн бүртгэлийг хурууны хээ мэдрэгч төхөөрөмжөөр байнга бүртгэж, ажлын цаг ашиглалтад 7 хоног бүр хяналт шалгалт хийж, дүнг Газрын шуурхай зөвлөгөөнд танилцуулан ажиллаж байна. Мөн ажилтан, албан хаагчид ажлын байранд үүрэгт ажлаа чанартай үр дүнтэй гүйцэтгэж буй эсэхэд Дотоод хяналт–шинжилгээ, үнэлгээний ажилтнаас тогтмол хяналт тавин ажиллаж байна. | 100% | |
| 2018 оныг “Хариуц- -лагын жил” болгон зарлах тухай 2018.01.31-ний өдрийн 32 дугаар тогтоол | 1.10 | Ажлын байран дахь бүх хэлбэрийн хууль бус дарамт шахалт, ялгавартай хандах үйлдлийг таслан зогсоож, ийм үйлдэл гаргасан албан тушаалтанд хүлээлгэх хариуцлагын талаар байгууллагын дотоод журамд тусган мөрдүүлж, эерэг уур амьсгалтай, сэтгэл зүйн дарамтгүй ажиллах орчныг бүрдүүлэх арга хэмжээ авах | - Газрын хөдөлмөрийн дотоод журмын 7 дугаар зүйл, Ёс зүйн журмын 3, 4 дүгээр зүйлд хууль бус дарамт шахалт үзүүлэх, ялгаварлан гадуурхах байдлыг хориглосон зохицуулалт оруулж, уг үйлдлийг удаа дараа давтан гаргасан ажилтан, албан хаагчид ажлаас чөлөөлөх хүртэл сахилгын шийтгэл ногдуулахаар тусгасан. Цаашид эерэг уур амьсгалтай, сэтгэл зүйн дарамтгүй ажиллах орчныг бүрдүүлэхэд анхааран ажиллана. | 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 3 | Төрийн албаны соёл, дэг журмыг сахиулах, ажлын цаг ашиглалт, ажлын бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор гэнэтийн болон төлөвлөгөөт хяналт шалгалтыг холбогдох байгууллагатай хамтран төрийн байгууллагуудад тогтмол зохион байгуулж ажиллахыг Монгол улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Г.Занданшатарт, өөрийн эрхлэх асуудлын хүрээний Засгийн газрын агентлаг, төрийн бусад байгууллагад хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж байгууллагын дарга нарт даалгасугай. | - Газрын даргын баталсан удирдамжийн дагуу ажлын хэсэг 2018.09.03-ны өдрөөс 2018.09.17-ны өдрүүдэд НЗЗ-ны 2 дугаар байрны зоогийн газар, 1, 5 дугаар байрны цайны газрын орчин, эрүүл ахуйн нөхцөл, зоогийн газрын хэрэгслийн угаалга, цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт, техник тоног төхөөрөмжинд тавигдах шаардлага, түүхий эд хүлээн авах, хадгалах нөхцөл болон ажиллагсдын эрүүл ахуй, ариун цэвэрт хяналт-шинжилгээ хийж, илэрсэн зөрчил дутагдлыг тухай бүр шаардлага тавин арилгаж ажиллаа. | 100% | |
| Хэсгийн дундаж: 100 хувь | | | | | |
| 1.ё.Ерөнхий сайдын захирамж | | | | | |
| | | | | | |
| **1.ж.Засгийн газрын хуралдааны тэмдэглэл** | | | | | |
| 2018.04.04-ний өдрийн 16 дугаар тэмдэглэл | ХҮ 2 | Ажлын байранд ажлын цагаар интернет ашиглан олон нийтийн сүлжээнд нэвтрэх, албан ажилд хамаарахгүй үйл | - Ажлын байранд ажлын цагаар интернет ашиглан олон нийтийн сүлжээнд нэвтрэх байдлыг бүрэн хязгаарласнаар уг албан даалгавар газрын хэмжээнд бүрэн хэрэгжсэн тул цаашид хяналтаас хасуулах саналтай байна. | 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | ажиллагаа явуулахыг хориглох асуудлыг байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд тусган хэрэгжүүлэх, төрийн албан хаагчийн ажлын цаг ашиглалт, ажлын бүтээмжийг сайжруулах арга хэмжээ авч ажиллах | | | |
| Хэсгийн дундаж: 100 хувь | | | | | |
| **1.з.Засгийн газрын албан даалгавар** | | | | | |
| Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай 2017.10.26-ны өдрийн 01 тоот албан даалгавар | 1.1 | Иргэндээ ээлтэй хуулийн засаглалыг бэхжүүлэх, Төрийн бүх шатны байгууллагын албан хаагчид шударга ёс, хууль дээдлэх зарчим баримтлан, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, улс төрөөс ангид, мэргэжлийн өндөр мэдлэг, ур чадвартай ажиллах | - Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг нийт ажилтан, албан хаагчдад сурталчлан таниулах зорилтын хүрээнд байгууллагын удирдлагуудын зүгээс нийт ажилтан, албан хаагчдын өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавьж, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахин, мэргэжлийн ур чадвартай ажиллахыг үлгэрлэн ажиллаж байна. | 100% | |
| | 1.2 | Авлигын хяналтыг сайжруулах, Төрийн албыг хувийг ашиг сонирхлын хэрэгсэл болгох гэсэн оролдлогыг тухай бүрт нь таслан зогсоож, авлига, хээль хахууль, хүнд суртал, шударга бус байдалтай шат шатандаа тууштай тэмцэх | “НҮГ-ын хэмжээнд 2018 онд хэрэгжүүлэх авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний дагуу дараах ажлыг хэрэгжүүлээд байна. Үүнд:<br>- Ажлын байрны сул орон тооны зар, холбогдох утасны дугаар, хаягийн мэдээллийг www.khangardi.mn сайтад байршуулан нийтэд мэдээлж байна.<br>- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн нээлттэй хэлбэрээр зохион байгуулан ажиллаж байна. | 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 1.3 | Иргэдээ сонсож, төрийн албаны хариуцлагыг өндөржүүлэх, “Засгийн газрын иргэд, олон нийттэй харилцах төв”-д иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шуурхай нягтлан шалгаж, асуудлыг шийдвэрлэн, дутагдал гаргасан холбогдох албан тушаалтанд тухай бүх хариуцлага тооцож ажиллах | - 2018 оны 3 дугаар улиралд газрын хэмжээнд нийт 57 өргөдөл, хүсэлт ирснээс 56 өргөдлийг шийдвэрлэж, хариуг холбогдох этгээдэд биечлэн хүргүүлсэн байна. Байгууллагад ирсэн өргөдлийг чиглэлээр нь тодруулбал цалинтай болон цалингүй чөлөө хүсэх тухай өргөдөл 16, ажлаас чөлөөлөгдөх болон байгууллага дотор шилжин ажиллах тухай хүсэлт 24, тусламж дэмжлэг, цалин хөлстэй холбоотой хүсэлт 10, ээлжийн болон жирэмсний амралттай холбоотой хүсэлт 5, бусад чиглэлээр 2 өргөдөл хүсэлт иржээ. | 100% | |
| | 1.4 | Төрийн албаны үр ашгийг сайжруулах, Ажилтан, албан хаагчдын цаг ашиглалт ажлын бүтээмжийг сайжруулах, үүрэгт ажлаа чанартай, үр дүнтэй хийж гүйцэтгэх, ажлын байрны дэг журмыг чанд сахих | - Ажилтан, албан хаагчдын ажлын цагийн бүртгэлийг хурууны хээ мэдрэгч төхөөрөмжөөр бүртгэн, 2018.09.01-ний өдрөөс ажлаас хоцорсон болон эрт тарсан ажилтан, албан хаагчдад ногдуулах хариуцлагыг түүнд олгох ур чадварын нэмэгдэлтэй уялдуулан хасч тооцохоор төлөвлөн ажиллаж байна. | 100% | |
| | 2.1 | Албан тушаалтны сахилга, хариуцлагыг өндөржүүлж, аливаа ажил, асуудлыг шуурхай зохион байгуулж, гүйцэтгэлийн явц үр дүнд тавих хяналтыг сайжруулан, хүлээлгэх хариуцлагыг чангатгаж, төрийн албаны стандартыг мөрдүүлж ажиллах | - Албан тушаалтны сахилга, хариуцлагыг өндөржүүлж, аливаа ажил, асуудлыг шуурхай зохион байгуулан, гүйцэтгэлийн явц үр дүнд тавих хяналтыг сайжруулах ажлын хүрээнд Газрын даргын дэргэдэх зөвлөлийн хурал 2018 оны 3 дугаар улиралд 3 удаа хуралдаж, ажилтан бүрийн сахилга хариуцлагыг дээшлүүлэх талаар үүрэг даалгавар өглөө.<br>- Захиргаа, санхүүгийн ажиллагсдын шуурхай зөвлөгөөн 2018 оны 3 дугаар улиралд нийт 3 удаа хуралдаж, газрын хэмжээнд шийдвэрлэх асуудлыг шуурхай зөвлөлдөн, үүрэг даалгавар өгч, хэрэгжилтийг эргэн танилцуулан эргэх холбоотой ажиллаж байна. | 100% | |
| | 2.3 | Төрийн албаны тухай хууль тогтоомж, дүрэм журмыг | - Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх ажлыг хэрэгжүүлснээр 2018 оны 3 дугаар | 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | хэрэгжүүлж, төрийн байгууллагын ил тод, нээлттэй байдлыг хангах, сайн засаглалыг бэхжүүлэн, иргэд, аж ахуйн нэгжид төрийн үйлчилгээ үзүүлэхдээ хүнд суртал, чирэгдэл, ёс зүйн доголдол гаргахгүй байх | улиралд 70 гаруй хүндэтгэлийн хүлээн авалтыг зохион байгуулж, 3505 хүнд үйлчилгээ үзүүлэхийн зэрэгцээ 15 удаагийн хурлын цай, завсарлагааг зохион байгуулж, 1500 хүнд үйлчилсэн байна. Түүнчлэн хээрийн зоогийн үйлчилгээг 4 удаа зохион байгуулж 325 хүнд зоогийн үйлчилгээг амжилттай үзүүлсэн байна.<br>- НЗЗ-ны байруудын инженерийн шугам сүлжээний хэвийн, найдвартай ажиллагааг хангаж, урьдчилан сэргийлэх үзлэг хийхийн зэрэгцээ эвдрэл, гэмтэл гарсан тухай нийт 2160 дуудлагын дагуу манай инженер, техникийн ажиллагсад үзлэг хийж, гарсан эвдрэл гэмтлийг газар дээр нь шуурхай засварлаж ажилласан байна. | | |
| | 2.4 | Хууль тогтоомж зөрчсөн, зөрчил дутагдал гаргасан, ажлаа цалгардуулсан албан тушаалтанд холбогдох хуулийн дагуу тухай бүр хариуцлага тооцож, зохих байгууллага, албан тушаалтанд мэдээлж байх | - Хариуцсан ажил үүрэгтээ хайнга хариуцлагагүй хандсан, ёс зүйн зөрчил дутагдал гаргасан нийт 3 ажилтанд Газрын даргын дэргэдэх зөвлөлийн хурал болон Ёс зүйн зөвлөлийн хурлаас сахилгын шийтгэл ногдуулах санал гарч 3 ажилтанд сануулах сахилгын шийтгэл ногдуулжээ. | 100% | |
| | 2.5 | Удирдлага, ажилтнуудын хөдөлмөрийн болон үр дүнгийн гэрээг хагас бүтэн жилээр дүгнэж, гүйцэтгэлийн үр дүнг урамшуулал, хариуцлагатай холбож ажиллах | - Уг ажлын хүрээнд ажилтан, албан хаагчдын 2018 оны 3 дугаар улирлын ажлын төлөвлөгөөний биелэлтийн мэдээг 2018.09.20-ны өдрийн дотор хүлээн авч, ур чадварыг үнэлэх ажлыг 2018.10.01-ний өдрөөс 2018.10.04-ний өдрүүдэд зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. | 90% | Ур чадварыг үнэлэх хугацаа болоогүй |
| | 5. | Албан даалгаврын хэрэгжилтийг жилийн эцсээр дүгнэж тайлангаа ирүүлэхийг Засгийн газрын гишүүд, аймаг нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгож байна. | - НҮГ нь Засгийн газрын 2017 оны 01 дүгээр албан даалгаврыг нийслэлийн хэмжээнд хэрэгжүүлэх төлөвлөгөөний биелэлтийн мэдээг сарын бүр гарган, НЗДТГ-ын ХШҮХ-т хүргүүлэн ажиллаж буй болно. | 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Хэсгийн дундаж: 99,01 хувь | | | | | |
| Хүүхдийн эрх, аюулгүй байдлыг хангах тухай<br><br>2018.07.09-ний өдрийн 01 тоот албан даалгавар | 2.1.1 | Төрийн байгууллагуудад хүүхдийн эрх, хамгаалал, хүүхдийн хөгжлийн онцлог, хүмүүжлийн эерэг арга, гэр бүлийн харилцаа сэдвүүдээр сургалт, сонсголыг тогтмол зохион байгуулах, бүх байгууллагуудад “Эцэг эхийн зөвлөл” байгуулж, хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэн ажиллуулах | - Газрын даргын А/53 дугаар тушаалаар НҮГ-ын “Эцэг эхийн зөвлөл”-ийг байгуулсан.<br>- 2018.09.22-ны өдөр газрын нийт ажилтан, албан хаагчид гэр бүлийн хамт Чингэлтэй ууланд авирч, “Эцэг – эх – хүүхэд” өдөрлөг зохион байгууллаа.<br>- Мөн мэдээллийн булан ажиллуулж, хүүхэд хамгааллын асуудлаар шаардлагатай мэдээ мэдээллийг байршуулан ажиллаж байна. | 100% | |
| | 2.1.2 | Албан тушаалтны сахилга хариуцлагыг өндөржүүлж, хүүхэд хамгаалалтай холбоотой асуудлыг цаг алдалгүй шуурхай зохион байгуулж, дотоод, гадаад орчинд эрсдлийн үнэлгээ хийж, хүүхдийн асуудлаар ямар нэгэн алдаа гаргасан албан тушаалтанд хариуцлага тооцож, зохих байгууллага, албан тушаалтанд мэдээлж байх. | - Газрын даргаас өгсөн үүрэг даалгаврын дагуу Нийслэлийн засаг захиргааны байруудын ойр орчмын эрсдэлтэй хэсгүүдийг тодорхойлж, ил гарсан цахилгааны утсыг далдалж, унаж бэртэж болзошгүй замын саадыг арилган тэгшилж, тохижуулан, зам талбайн аюулгүй байдлыг хангасан. Мөн Нийслэлийн засаг захиргааны бүх байруудад хөгжлийн бэрхшээлтэй иргэний гарцтай болсон. | 100% | |
| Хэсгийн дундаж: 100 хувь | | | | | |
| Нийт дундаж 99.01 хувь | | | | | |
| **1.к.Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоол** | | | | | |
| Иргэдийн амьдрах | 1.3.1 | Нийслэлийн нутаг дэвгэрт үйл ажиллагаа явуулж байгаа | - Нийслэлийн засаг захиргааны бүх байруд болон Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвүүд хөгжлийн | 100% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| орчны аюулгүй байдлыг ханган чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай 2018.07.09-ний 11 дүгээр тогтоол | | байгууллага бүр өмчийн харьялал үл хамааран орчны тохижилт, эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангах, стандартын шаардлага баримтлан хөгжлийн бэрхшээлтэй иргэн, насанд хүрээгүй хүүхэд зэрэг онцгой анхаарал халамж шаардах иргэдийн эрх ашгийг нэн тэргүүнд хангасан байх | | бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хангах үүднээс зориулалтын бариул, талбай бүхий зорчих хэсэгтэй болсон. | | |
| | 1.3.5 | Мэргэжлийн байгууллагын тавьсан шаардлага, сануулга, мэдээллийг ойр орчны иргэд, хүүхэд залуучуудад уламжлах, мэдээлэх, сэргийлэх. | - | Мэргэжлийн байгууллагаас тавьсан шаардлагын дагуу Нийслэлийн засаг захиргааны байрууд болон Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвүүдийн ойр орчны цахилгааны ил утас, хүчдэл бүхий төхөөрөмжийн аюулгүй ажиллагааг хангаж ажиллаж байна. | 100% | |
| | 2.2.2 | Албан тушаалтны сахилга хариуцлагыг өндөржүүлж, хүүхэд хамгаалалтай холбоотой асуудлыг цаг алдалгүй шуурхай зохион байгуулж, дотоод гадаад орчинд эрсдэлийн үнэлгээ хийж, хүүхдийн асуудлаар ямар нэгэн алдаа гаргасан албан тушаалтанд хариуцлага тооцож, зохих байгууллага, албан тушаалтанд мэдээлж байх. | - | Албан тушаалтны сахилга хариуцлагыг өндөржүүлэхэд онцгой анхаарч, хүүхэд хамгаалалтай холбоотой асуудлыг цаг алдалгүй шуурхай зохион байгуулж ажиллах зорилгоор газрын даргын А/53 дугаар тушаалаар “Эцэг эхийн зөвлөл” байгуулсан. Өнөөдрийн байдлаар хүүхдийн асуудлаар ямар нэгэн алдаа гаргасан ажилтан, албан хаагч гараагүй байна. | 100% | |
| Журам батлах тухай 2017.06.07-ны өдрийн | 1. | “Нийслэлийн эрх зүйн мэдээллийн нэгдсэн санг эрхлэн хөтлөх журам”-ыг хавсралтаар баталсугай. | - | Нийслэлийн эрх зүйн мэдээллийн нэгдсэн сан www.ublegal.mn сайтыг хууль эрх зүй, тогтоол шийдвэрийн хэрэгжилт хариуцсан ажилтан хөтөлж, байгууллагын А болон Б тушаалыг тогтмол байршуулан ажиллаж байна. | 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 90 дүгээр тогтоол | | | | | |
| | 2.3 | Санд бүртгэж, хөтөлсөн баримт бичгийн мэдээ, тайланг улирал бүр гаргах ба дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Ажлын алба нь нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын Ажлын албанд, бусад байгууллага нь нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт, шинжилгээ үнэлгээний хэлтэст дараа улирлын эхний сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ. | - НҮГ-ын 2018 оны 02 дугаар улирлын Нийслэлийн эрх зүйн мэдээллийн нэгдсэн санд бүртгэж, хөтөлсөн баримт бичгийн мэдээ, тайланг 2018.07.10-ны өдрийн 372 дугаар албан бичгийн хавсралтаар НЗДТГ-ын ХШҮХ-т илгээсэн байна. Хууль эрх зүй, тогтоол шийдвэрийн хэрэгжилт хариуцсан ажилтны зүгээс 2018 оны 3 дугаар улиралд батлагдсан А дугаартай 17 тушаал, Б дугаартай 99 тушаал, шийдвэрийг тухай бүр сайтад байршуулан ажиллахыг зэрэгцээ тайланг 2018.10.10-ны өдрийн дотор НЗДТГ-ын ХШҮХ-т илгээхээр төлөвлөн ажиллаж байна. | 100% | |
| Хэсгийн дундаж: 100 хувь | | | | | |
| Нийт дундаж 100% хувь | | | | | |
| **1.к.Нийслэлийн Засаг даргын захирамж** | | | | | |
| Эрх шилжүүлэх тухай<br><br>2018.02.19-ний өдрийн А/142 дугаар захирамж | 2 | Энэ захирамжийн хавсралтад заасан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны эрхийг Нийслэлийн Засаг даргаас Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газар /Х.Эрдэнэбилэг/-т шилжүүлж, холбогдох хууль тогтоожид нийцүүлэн зохион байгуулан, дүнг танилцуулж ажиллахыг даалгасугай. | - Газрын даргын 2018.08.01-ний өдрийн А/43 дугаар тушаалаар байгуулагдсан үнэлгээний хороо 2018.08 24-ний өдөр хуралдаж, НЗЗ-ны байруудын засварын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан. Ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахад “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн 33.1, 33.2-т зааснаар техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангаж байгаа 3 ба түүнээс дээш хуулийн этгээдэд үнийн санал ирүүлэхийг мэдэгдсэн ба уг мэдэгдлийн дагуу үнийн санал ирүүлсэн хуулийн этгээдээс мөн хуулийн 27, 28 дугаар зүйлийг баримтлан | 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | сонгон шалгаруулж, “хамгийн сайн” үнэлэгдсэн “Мөнгөн Оройт Цамхаг” ХХК, “Дус Монголиа” ХХК, “Сагсай Өргөө” ХХК, “Модерн Хийц” ХХК-иудад гэрээ байгуулах эрх олгохоор шийдвэрлэсэн. Энэ тухай дээрх шалгарсан гүйцэтгэгч нарт, мөн бусад тендерт оролцогч нарт шалгараагүй үндэслэлийг нэгэн зэрэг бичгээр мэдэгдсэн болно.<br>- Дээрх шалгарсан гүйцэтгэгч нартай гэрээ байгуулах зөвлөмжийг 2018.09.03-ны өдрийн албан тоотоор Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газарт хүргүүлснээр гэрээ байгуулагдан, засварын ажлыг эхлүүлээд байна. | | |
| | 2 | Энэ захирамжийн хавсралтад заасан төсөл, арга хэмжээг гүйцэтгэлээр нь санхүүжүүлэхийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс /Э.Ганхүү/-т, захиалагчийн хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар /Ц.Ариунбаяр/-т, хөрөнгө оруулалтын дүнд бий болсон хөрөнгийг нийслэлийн өмчид бүртгэн авч, эзэмшил ашиглалтад хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар /Ч.Однасан/-т тус тус үүрэг болгосугай. | - Захирамжлалын баримт бичгийн энэхүү заалт нь манай байгууллагад хамааралгүй байх тул хяналтаас хасуулах саналтай байна. | 100% Хяналтаас хасуулах саналтай байна. | |
| 2018.04.18-ны өдрийн А/333 дугаар | 1. | 1. Төсвийн хөрөнгө, гадаадын зээл, тусламж болон бусад эх үүсвэрээр тухайн онд зохион байгуулах худалдан авах | Уг захирамжийн дагуу дараах ажлыг хэрэгжүүлсэн байна:<br>- Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын 2018.06.14-ний өдрийн 01/749 дүгээр мэдэгдлийн дагуу | 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| захирамж<br><br>Худалдан авах ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах зарим арга хэмжээний тухай | | ажиллагааны төлөвлөгөө, тайланг баталсан маягтын дагуу боловсруулан батлуулж, зохих журмын дагуу холбогдох газарт хүргүүлэн, хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлж ажиллахыг НХААГ-т, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланг тогтоосон хугацаанд НХААГ-т хүргүүлж, шилэн тендерийн бүртгэлийн системд оруулж ажиллахыг нийслэлийн төр, захиргааны байгууллага тус тус даалгасугай. | сар бүрийн 01-ний өдрийн дотор өмнөх сард зохион байгуулсан худалдан авах ажиллагааны тайланг гаргаж, тус газарт хүргүүлэн ажиллаж байна.<br>- НҮГ нь бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг үнэлгээний хорооны саналыг үндэслэн шууд худалдан авалтын арга болон харьцуулалтын аргаар сонгон шалгаруулж, холбогдох хууль дүрмийг баримтлан, ил тод байдлыг эрхэмлэн ажиллаж байна. | | |
| Нийслэлийн 2017-2018 оны өвөлжилтийн дүн, 2018-2019 оны өвөлжилтийн бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай<br><br>2018.06.05-ны өдрийн А/515 дугаар | 1 | Нийслэлийн 2017-2018 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангахад идэвх, санаачилгатай ажилласан байгууллагын ажилтнуудыг шагнаж, урамшуулахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга М.Отгонбаяр, Улаанбаатар хотын ерөнхий менежер бөгөөд Захирагчийн ажлын албаны дарга Т.Гантөмөр нарт, албан үүргээ хангалтгүй биелүүлсэн ажилтнуудад хариуцлага тооцож, цаашид алдаа дутагдал гаргахгүй байх тал дээр анхаарч ажиллахыг холбогдох байгууллагын удирдлагуудад тус тус үүрэг | - Энэхүү захирамжид тусгасан эрх хэмжээг манай байгууллага хэрэгжүүлэх боломжгүй тул хяналтаас хасуулах саналтай байна. | 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| захирамж | | болгосугай. | | | |
| | 2 | Энэ захирамжийн хавсралтад заасан ажлыг 2018 онд хэрэгжих инженерийн шугам сүлжээ, авто зам, тохижилтын ажлын нэгдсэн төлөвлөгөөтэй уялдуулан зохион байгуулж, шаардлагатай хөрөнгийг шийдвэрлэн, биелэлтийг 2018 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор хангуулж ажиллахыг дүүргүүдийн Засаг дарга нар болон холбогдох байгууллагын удирдлагуудад даалгасугай. | - | | |
| Хэсгийн дундаж: 100 хувь | | | | | |
| Нийт дундаж: 100 хувь | | | | | |

ХЯНАЖ, ТАНИЛЦСАН

ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА Ч.ШИНЭЧИМЭГ

ДОТООД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭНИЙ АЖИЛТАН Т.ИТГЭЛ

ТАЙЛАН ГАРГАСАН:

ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ ХАРИУЦСАН АЖИЛТАН Э.ХОРОЛДУЛАМ